

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2010 оны 11 дүгээр сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2010 оны 11 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

/тоогоор/					
№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт	2010-X	Нэмэгдсэн	Хасагдсан	2010-XI
1	Даатгалын компани	16			16
2	Даатгалын компанийн салбар	137	1 ¹		138
3	Даатгалын төлөөлөгч	2022			2022
4	Даатгалын зуучлагч	8			8
5	Даатгалын хохирол үнэлэгч	6			6
6	Актуарч	11			11
7	Бусад		2 ²		

Тайлант үед даатгалын компани, даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, актуарчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны даргын 2010 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 163 дугаар тушаалаар “Түшиг даатгал” ХХК-д Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт салбар нээхийг зөвшөөрсөн.

²Хорооны 2010 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 346 дугаар тогтоолоор “Ард даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 500.0 сая төгрөг байсныг нэмэгдүүлж 1,000.0 сая төгрөг болгон тогтоохыг зөвшөөрсөн.

²Хорооны 2010 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 347 дугаар тогтоолоор “Номин даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 500.0 сая төгрөг байсныг нэмэгдүүлж 1,000.0 сая төгрөг болгон тогтоохыг зөвшөөрсөн.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2010 оны 11 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулбал:


Ердийн даатгалын компаниудын хувьд :

/төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	2009-XI	2010-XI
1	Даатгалын нийт хураамж	1,178,073,080.6	3,020,334,012.9
2	Олгосон нийт нөхөн төлбөр	813,073,617.6	356,415,489.8
3	Давхар даатгалд төлсөн хураамж	217,596,238.3	15,727,860.0

4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	4,347	7,072
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	5,500,000,000.0	60,023,500,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	250,000,000.0	73,371,229.0

2010 оны 11 дүгээр сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 1,842.2 сая төгрөгөөр өсч, олгосон даатгалын нөхөн төлбөр 456.6 сая төгрөгөөр, давхар даатгалд төлсөн хураамж 201.9 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн харьцаа



Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

		/төгрөгөөр/	
№	Үзүүлэлт	2009-XI	2010-XI
1	Даатгалын нийт хураамж	71,382,687.0	90,189,770.6
2	Олгосон нийт нөхөн төлбөр	714,000.0	5,934,352.5
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	-
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	780	11
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд		10
	-Байгууллагын хугацаат даатгалд		1
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		-

	-Эмнэлгийн мөнгөний даатгалд		-
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	30,000,000.0	15,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	390,000.0	2,000,000.0

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2010 оны 11 дүгээр сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулж үзэхэд даатгалын хураамжийн орлого 18.8 сая төгрөгөөр, нөхөн төлбөр 5.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

/төгрөгөөр/				
№	Үзүүлэлт	2010-IX	2010-X	2010-XI
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	33,275,321.4	21,348,153.3	29,574,894.9
2	Даатгалын зуучлагчийн орлого	14,192,906.4	6,459,185.1	21,524,396.0
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	60	6	18
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	3,650,768,510.9	3,818,051,962.6	5,138,752,188.0

2010 оны 11 дүгээр сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 18 даатгалын гэрээг даатгагчдад зуучлан 21.5 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна.

3.БУСАД МЭДЭЭЛЭЛ :

1.Хорооны 2010 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 345 дугаар тогтоолоор Даатгалын төлөөлөгчөөс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг бууруулан тогтоосон.